



Монгол нутаг дахь Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалын орчуулга

Б.Аззаяа* (МУИС)

Монгол нутаг дахь руни бичгийн дурсгалуудыг эрдэмтэн судлаачид бичлэгийн тиг хэлбэр, агуулга, зориулалтыг нь үндэслэн сонгодог хийгээд бага бичгийн дурсгал, харин холбогдох түүхэн үеэр нь эртний Түрэгийн үеийн, Уйгурын үеийн хэмээн ангилдаг билээ.

Эртний Түрэгийн II хаант улсын үед холбогдох Билгэ хаан, Көлтигин, Туныюкук нарт зориулан босгосон гэрэлт хөшөөг руни бичгийн сонгодог дурсгалын гурван оргил хэмээн нэрлэх бөгөөд эдгээр дурсгалын орчуулга, судалгаа дэлхийн олон хэл, бичгээр буй. Хэдий тийм боловч эртний Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалын орчуулга, судалгаа төдий л хангалттай бус ажээ. Тухайлбал, Моюнчурын гэрэлт хөшөө буюу Могойн шинэ усны дурсгалыг нэрт эрдэмтэн Г.И.Рамстедт илрүүлж “Сэлэнгийн чулуу” хэмээн нэрлэн уншиж судалж герман хэлнээ орчуулжээ⁷⁴. Түүний дараагаар С.Е.Малов⁷⁵, Г.Айдаров⁷⁶, Х.Оркун⁷⁷, Т.Мориясу⁷⁸, Жөн Жай хүн⁷⁹, Эрхан Айдын⁸⁰, Осман Мерт⁸¹, Л.Ю.Тугушева⁸², С.Г.Кляшторный⁸³ нарын эрдэмтэд

*МУИС-ийн ГХСС-ийн Түрэг судлалын тэнхим, докторант

⁷⁴ Г.И.Рамстедт, Как был найден Селенгинский камень, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том IV, Вып.1, Санктпетербург, 1914; Г.И.Рамстедт, Перевод надписи Селенгинского камня, Труды Троицко-Кяхтинского отделения Императорского Русского Географического общества, Том XV, Вып.1, Санктпетербург, 1914; G.J.Ramstedt, Zwei uigurische Runeninschriften in der Nord-Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Vol.XXX, N 1, Helsinki, 1913; Gustav John Ramstadt, Seven Journeys Eastward (1898-1912), Translated from the Swedish & edited by John R.Krueger, The Mongolia Society, 1978, Bloomington, Indiana; G.J.Ramstedt, J.G.Granö und P.Aalto, Materialien zu den alttürkischen Inschriften der Mongolei, -Journal de la Société Finno-Ougrienne, Vol.LX, N 3, Helsinki, 1958.

⁷⁵ С.Е.Малов, Памятники древнетюркской письменности Монголии и Киргизии, Москва Ленинград, 1959, стр.30-44.

⁷⁶ Г.Айдаров, Язык орхонских памятников древнетюркской письменности VIII века, Алма-Ата, 1971, 339-352 дугаар тал.

⁷⁷ Hüseyin Namık Orkun, Eski türk yazıtları, Ankara, 1986, s.161-186

⁷⁸ 森安孝夫・シネウス遺蹟・碑文・モンゴル国現存遺跡・碑文調査研究報告・中央ユーラシア学研究会・1999年3月 (Takao Moriyasu, Saite and Inscription of Šine-Ušu, -Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999), pp. 177-196;

⁷⁹ 정재훈, 위구르유목제국사 (744-840), 서울, 2005, 429-452

⁸⁰ Erhan Aydın, Şine Uşu Yazıtı, Çorum, 2007; Erhan Aydın, Uygur Kağanlığı Yazıtları, Konya, 2011

⁸¹ Osman Mert, Ötüken Uygur Dönemi Yazıtlarından Tes-Tariat-Şine Us, Ankara, 2009

судлан орос, англи, япон, солонгос болон түрк хэлээр орчуулжээ. Гэвч энэхүү дурсгалыг монгол хэлнээ орчуулсан нь үгүй ажээ. Харин Тариатын бичээсийг 1956 онд археологич Ц.Доржсүрэн анх олж илрүүлж⁸⁴, монгол хэлнээ М.Шинэхүү⁸⁵, Б.Базылхан⁸⁶, Л.Болд⁸⁷, орос хэлнээ С.Г.Кляшторный⁸⁸, С.Харжаубай⁸⁹, англи хэлнээ Т.Текин⁹⁰, А.Катаяма⁹¹, солонгос хэлнээ Жөн Жай хүнь⁹², түрк хэлнээ Осман Мерт⁹³, Эрхан Айдын⁹⁴ нар уншиж судалсан байна. Харин Хатиже Ширин үгсийн сангийн үүднээс судалжээ⁹⁵.

Уйгурын үеийн руни бичгийн сонгодог дурсгалуудыг судалсан эрдэмтэд үгчлэн орчуулахаас зайлсхийж, аль болох утгачилан буулгаж тайлбар хийхийг чухалчилсан байна.

Утгачилсан, тайлбарт орчуулга хэдийгээр ухаж ойлгоход хялбар боловч үгийн үндсэн утга, хувилал зэргийг бүдгэрүүлж сурвалжийн эхийн үнэ цэнийг буруулах талтай гэж эх бичиг судлаач эрдэмтэд үзсэн байдаг билээ. Тиймээс Уйгурын үеийн сонгодог дурсгалын үгчилсэн орчуулга хийж, утгачилсан орчуулгуудтай харьцуулж үзэхэд багагүй алдаа мадаг байгаа нь ажиглагдсан болно. Хэдийгээр бидний үгчилсэн орчуулгатай яв цав нийцэх албагүй ч, уг дурсгалыг зөв тайлж унших, сурвалжийн үнэн зөв мэдээллийг буй болгоход чухал ач холбогдолтой билээ. Орчуулгын харьцуулалтаас үзэхэд дараах хэдэн шалтгаанаас үүдсэн зөрүү ажиглагдаж байна. Үүнд:

⁸² Л.Ю.Тугушева, Тюркские рунические письменные памятники из монголии, Москва, 2008

⁸³ С.Г.Кляшторный, Рунические памятники Уйгурского каганата и история Евразийских степей, Санкт-Петербург, 2010

⁸⁴ Ц.Доржсүрэн, 1956-1957 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай, Улаанбаатар, 1958.

⁸⁵ М.Шинэхүү, Памятник рунической письменности из Тариата, -Роль кочевых народов в цивилизации Центральной Азии, Улаанбаатар, 1974, 327-331 дүгээр тал; М.Шинэхүү, Тариатын орхон бичгийн шинэ дурсгал, - Studia Archaeologica, Tom.VI, fasc.1, 1975, тал.219; М.Шинэхүү, Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал, -Археологийн судлал, Tom.VIII, fasc.1, Улаанбаатар, 1980, тал. 83.

⁸⁶ Б.Базылхан, Тэрхийн түрэг бичээс, -Studia Mongolica, Tom.VIII (16), fasc.12, Улаанбаатар, 1980, тал.163-175.

⁸⁷ Л.Болд, Тариатын орхон бичээс, - Орхон бичгийн дурсгал II, Улаанбаатар, 2006

⁸⁸ С.Г.Кляшторный, Терхинская надпись (предварительная публикация), -Советская Тюркология, №3, стр. 82-95; S.G.Klyashtorny, The Terkhin Inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Tom. XXXVI, fasc.1-3, 1983, pp.335-366, -18 pls.

⁸⁹ С.Харжаубай, Второй Памятник Ель-Етмиш Бильге кагана (Терхинская (Тариатинская) стела), - Объединенный каганат Тюрков в 745-760 годах (по материалам рунических надписей), Астана, 2002, стр.32-52.

⁹⁰ Talat Tekin, Kuzey Moğolistan'da yeni bir uygur anıtı: Taryat (Terkhin) kitabesi, - Türk Tarihi Kurumu, Belleten, Tom.XLVI, № 184, s.895-838; Talat Tekin, The Tariat (Terkhin) inscription, - Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Tom. XXXVII (1-3), 1983, pp.43-68.

⁹¹ 大澤 孝, イフ=ハヌイ=ノール遺跡*銘文, -モンゴル国現存遺跡・碑文調査研究報告, 責任編集, 森安 孝夫・オチル, 中央ユーラシア学研究会, 1999, ページ 137-140. (Akio Katayama, Tariat Inscription, - Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998, The Society of Central Eurasian Studies, 1999, pp. 168-176.)

⁹² 정재훈, 위구르유목제국사 (744~840), 서울, 2005, ...413-428

⁹³ Osman Mert, Ötüken Uyğur Dönemi Yazıtlarından Tes-Tariat-Şine Us, Ankara, 2009

⁹⁴ Erhan Aydın, Uyğur Kağanlığı Yazıtları, Konya, 2011

⁹⁵ Hatice Şirin User, Köktürk ve Ötüken Uyğur Kağanlığı Yazıtları (Söz Varlığı İncelemesi), Konya, 2009

1. Үсэг тэмдэгтийг өөрөөр уншиж тайлснаас үүдсэн орчуулгын зөрүү
2. Үсэг тэмдэгтийг ижил сэргээсэн авч амилуулан уншихаас үүдсэн орчуулгын зөрүү
3. Хам сэдэвт хэтэрхий дулдуйдсанаас үүдсэн орчуулгын(утгын) зөрүү
4. Үсэг тэмдэгт, амилуулан сэргээсэн нь ижил боловч утгыг зөрүүтэй буулгасан зэрэг болно.

Эдгээр зүйл тус бүрийг Тэсийн гэрэлт хөшөөний бичээсийн орчуулгын жишээгээр авч үзье. Уйгурын үед холбогдох руни бичгийн сонгодог дурсгалын нэг болох Тэсийн гэрэлт хөшөөг 1976 онд Хөвсгөл аймгийн Цагаан уул сумын Өвөр булгийн Хөх толгой хэмээх газраас Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан хээрийн шинжилгээний анги олж илрүүлсэн бөгөөд бичээсийг монгол хэлнээ түрэг судлаач М.Шинэхүү⁹⁶, С.Харжаубай⁹⁷, Л.Болд нар⁹⁸ нар орчуулжээ. Харин орос хэлнээ С.Г.Кляшторный⁹⁹, англи, япон хэлнээ Такаши Осава¹⁰⁰, орчин цагийн түрк хэлнээ Осман Мэрт¹⁰¹, Эрхан Айдын¹⁰² нар орчуулсан байна.

*Үсэг тэмдэгтийг өөрөөр уншиж тайлсантай холбогдон гарах орчуулгын зөрүү*¹⁰³

Тэсийн гэрэлт хөшөө:

W4 ууyur qanīm tutulmīs¹⁰⁴ (Уйгур хаан минь баригджээ.)

(Шинэхүү, 1980, р. 41) Уйгур хан мину улсыг эзэгнэв.

(Харжаубай, 1979, р. 122) Уйгур удмыг мину хүндэтгэн өргөмжлөв.

(Кляшторный, 2010, s. 88) когда мой уйгурский хан правил (эле́м)

W6 olurti¹⁰⁵ oylī tarduṣ yabyu tōlis čad olurti(сүүв. Хүү нь Тардушийн ябгу Телисийн шад суув.)

(Шинэхүү, 1980, р. 41) түүний ариун хөвгүүн тардуш ябгу, төлис чад шад суув.

(Харжаубай, 1979, р. 122) Хүчирхэг хөвгүн Тардуш явгу, Төлөс шад байлаа.

N1 tānri¹⁰⁶ qilintuq[da] ууyur qaγan olurmīs¹⁰⁷ (Тэнгэр үүсэхэд Уйгур хаан сүүжээ.)

(Шинэхүү, 1980, р. 41) дорно дахиныг тохинуулан уйгур хаган суув.

(Харжаубай, 1979, р. 122) дорныг тохинуулан Уйгур хаган суув.

⁹⁶ Шинэхүү, М. (1975). Тариатын орхон бичгийн шинэ дурсгал. *Studia Archaeologica, Tomus VI, Fasc.1*;

⁹⁷ Харжаубай, С. (1979). Тэсийн гэрэлт хөшөө. *Хэл зохиол судлал, Том. XIII, fasc. 15*, 117-124.

⁹⁸ Болд, Л. (2006). *Орхон бичгийн дурсгал II*. Улаанбаатар.

⁹⁹ Кляшторный, С. (2010). *Рунические памятники Уйгурского Каганата и история евразийских степей*.

Санкт-Петербург: Петербургское Востоковедение.

¹⁰⁰ Osawa, T. (1999). *Tes Inscription*. In *Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998* (pp. 158-167). The Society of Central Eurasian Studies.

¹⁰¹ Osman, M. (2009). *Ötüken Uygur Dönemi Yazıtlarından, Tes, Tariat, Şine Us*. Ankara.

¹⁰² Erhan, A. (2011). *Uygur Kağanlığı Yazıtları*. Копья.

¹⁰³ Бо: Л.Болд; К: С.Г.Кляшторный; О: Такаши Озава; М: Осман Мэрт; Х: С.Харжаубай; Ш: М.Шинэхүү;

¹⁰⁴ K *tut(t)uqda*; X *tutmis*; Ш *tutmis*;

¹⁰⁵ X *ariti*; Ш *ariti*;

¹⁰⁶ M *[te]n̄gri*; K *[...ö]n̄re*; X *ön̄rā*; Ш *onra*;

¹⁰⁷ X -;

(Кляшторный, 2010, р. 88) когда, в прежние времена, были сотворены (или: возникли)

N1 bök¹⁰⁸ uluу qayap... (Бөк Их хаан ...)

(Шинэхүү, 1980, р. 41) Чик(ийн) их хаган

(Харжаубай, 1979, р. 122) Чик/хэргэмтэй/ их хаган ...

N2 ...anīn¹⁰⁹ ili üč yüz yil il tutmīš

(Кляшторный, 2010, р. 88) триста лет множеством (букв.: тысячью) своих элей они правили.

N5 ... tabyačqa bazlanmīš¹¹⁰ uууr qayani toq¹¹¹ olurmīs yetmīs yil ārmīs
(...эрхшээгдсэн. Уйгур хаан цатгалан суужээ. Далан жил байжээ(=оршжээ).)

(Кляшторный, 2010, р. 88)... восстав на табгачей, они были разбиты. Уйгурские каганы десять лет (тогда) царствовали. (Потом еще) прошло семьдесят лет.

E3-tatdi¹¹² (...)

(Кляшторный, 2010, р. 89) эле́м правил.

E6 bulaqıy¹¹³ iya bašır olurđı¹¹⁴ .. (Булак-ыг эзэгнэн дарангуйлан сүүв...)

(Шинэхүү, 1980, р. 41) Йоллүг эзэн ахлан сүүв.

(Харжаубай, 1979, р. 122) Йоллүга эзэн ахлан байв.

E6 yärig yäg(ät)di¹¹⁵ ... (... газрыг(=нутгаа) тэлэв.)

(Шинэхүү, 1980, р. 41) ...(ихэд) зэвүүнэн төрүүлэв.

(Харжаубай, 1979, р. 122) газрыг нутаглав.

S1 ... köl¹¹⁶ bäg¹¹⁷ ... (...Көлнөөн...)

(Болд, 2006, р. 226) Күльбилгэ

S4 ...uyurmīs¹¹⁸ tay ... (... уйгур ажээ. Тая ...)

(Болд, 2006, р. 226)...уйгар минь. Тай

(Кляшторный, 2010, р. 89)...Мои уйгуры, Тай...

(Erhan, 2011, р. 37) Uygur'um.

¹⁰⁸ К b^akū; Х čik; Ш cik;

¹⁰⁹ К b^yη;

¹¹⁰ К qyz^a s^ynm^yš; Х bazlanmaš;

¹¹¹ М ..oq; К on jyl;

¹¹² М t(u)tdi: hakimiyeti altına aldı; О –dī; К tut[dy]; Х tutdi; Ш tutdi;

¹¹³ М ...u[(a)qıg; К [...b]ol qy; Х jolluy; Ш jolluy;

¹¹⁴ К ol^r[t]m^yš; Х olurmīs; Ш olurmīs;

¹¹⁵ М y(e)....di; Х jersebi; Ш jarsibi;

¹¹⁶ Бökül; К kül; Ш kil;

¹¹⁷ А beg; М b(e)g; Бöbel; К b^eg; Х kül-bignir; Ш bignir;

¹¹⁸ А uygurum; Бoуyurim; К uy^r'm; Х uyjurim; Ш uyjurim;

Үгээ тэмдэгтийг ижил сэргээсэн авч амилуулан уншихаас үүдсэн орчуулгын зөрүү
Тэсийн гэрэлт хөшөө:

W4 ayüntürti¹¹⁹ (өргөмжлөв.)

(Шинэхүү, 1980, р. 41) ... аривч

(Харжаубай, 1979, р. 122) хүчирхэг...

N1 bök¹²⁰ uluу qayan... (Бөк Их хаан ...)

(Кляшторный, 2010, р. 88) (они были мудрый и великие каганы)

N3 -mis boz oq¹²¹ başın aqıza¹²² uçuз¹²³ kölkä¹²⁴ atlüyin¹²⁵ tökä¹²⁶ barmis¹²⁷ (-жээ² Боз
ок(ын) тэргүүнийг нь үүлгалан Учүз нүүрнаа морьтонтой нь дайран оджээ.)

(Шинэхүү, 1980, р. 41) Бүзүк башын халив. Аз күк экэ нэрт үдирдагч мөхөв.

(Харжаубай, 1979, р. 122) бүсниулагчдын толгойлогч үхэж халив. Күл-еке нэрт ахлагч мөхөв.

(Erhan, 2011, s. 34) Boz ok(ların) liderini hücum ettirip (düşmanı) Uçuз Gölü'ne atlarıyla (birlikte) döküvermiş.

(Кляшторный, 2010, р. 88) ... Став мятежным из-за (наушений) вождей бүзүков (их народ?) погиб, из-за (подстрекательства) ничтожного Кюля и двухименитых (их народ) погиб.

N4 ol bodunim känkäräsdä¹²⁸ (Тэр ард түмэн минь Кэнгэрэс-т)

(Кляшторный, 2010, р. 88) Тот мой народ затевал многие (междоусобные) распри и ссоры.

E2anta adin¹²⁹ ödkünč¹³⁰ qayan ärmis¹³¹ (... Тэнд өөр хуурамч хаан байжээ.)

(Кляшторный, 2010, р. 89) После этого Од Кенч каганом стал.

E3 -tatdi¹³² (...)

(Шинэхүү, 1980, р. 41) ... барив.

¹¹⁹ M (a)g(i)ñt(u)rıtı; K ^aγ[ynturty]; X ...γanti ariti; Ш ... ariti;

¹²⁰ K b^akü; X čik; Ш cik;

¹²¹ K buzuq; X buzuq; Ш buzuq;

¹²² M (a)k(i)za: hücum ederek; O aqıza; K q^aza; X qaza; Ш qaza;

¹²³ Ш uč az;

¹²⁴ M köölke; K küł ^eki; X küł-eke; Ш kük äkä;

¹²⁵ X atalyan;

¹²⁶ M töke; K tüke; X tike; Ш tükä;

¹²⁷ X barti;

¹²⁸ M k(e)ñgk(e)r(e)sde; K k^eγ k^er¹šdi; X kenkeriste;

¹²⁹ K -d^an; X edin;

¹³⁰ K öd kenč; X ötkünč;

¹³¹ M (e)rm(i)š; K ^erm¹š; X ermis;

¹³² M t(u)ıdı: hakimiyeti altına aldı; O -di; K tut[dy]; X tutdi; Ш tutdi;

(Харжаубай, 1979, р. 122) ... байв.

(Osman, 2009, р. 133) ... hâkimiyeti altına aldı

(Erhan, 2011, р. 35) ... tuttu (düzenledi).

E6 bulaqı¹³³ ıya¹³⁴ başıp¹³⁵ olurtı¹³⁶ ... (Булак-ыг эзэгнэн дарангуйлан суув.)

(Болд, 2006, р. 226) ... (Тэр) Болукуыг бишрүүлэн захирч суув.

(Кляшторный, 2010, р. 89) ... вознося хвалу, его посадили главою (эля)...

S1 ... köl¹³⁷ bäg ... (... Көлнөөн ...)

(Шинэхүү, 1980, р. 41) Күлбигнир ...

(Харжаубай, 1979, р. 122) Күл-бигнир

S2 [t]äzig qaşar quıŋ qontı¹³⁸ (Касар(ын)баруунтаа Тээ-д нутаглав.)

(Шинэхүү, 1980, р. 41) ... хашига (хашиг) хоригий нь эвдлэв.

(Харжаубай, 1979, р. 122) ... хашиг хориг босгож

S2 [t]äzig qaşar quıŋ¹³⁹ qontı (Касар(ын)баруунтаа Тээ-д нутаглав.)

(Кляшторный, 2010, р. 89) ... он поселился на Тезе, в Касар Куруге, ...

S3 älsär¹⁴⁰ ilgärü qontı¹⁴¹ (Элсэр зүүнш нутаглав.)

(Шинэхүү, 1980, р. 41) ... эл үлс өргөн үудам дорныг түрэмхийлэн эзлэв.

(Харжаубай, 1979, р. 122) ... эл үлс өргөн үудам дорно зүгт нутаглав.

S3 bälgüsin bitigin bu urtı bu yaratdı¹⁴² (Тэмдгээ, бичгээ энэ цохив. Энэ бүтээв.)

(Шинэхүү, 1980, р. 41) Билигүүн үйлс бичиг юүгээн энд сийлэхийг соёрхов.

S4 ... uıyurmıs¹⁴³ tay¹⁴⁴ (... үйгүр ажээ. Тая ...)

(Шинэхүү, 1980, р. 41) ... үйгүр мину зургаан сар

(Харжаубай, 1979, р. 122) ... Уйгүр мину зургаан сар

Үсэг тэмдэгт, амилуулан сэргээсэн нь ижил боловч утгыг зөрүүтэй буулгасан

¹³³ Бо ... *boluqıy*; К [...b]ol quy;

¹³⁴ К *aja*;

¹³⁵ К *bʰşy*;

¹³⁶ К *olʰr[t]mʰş*;

¹³⁷ К *kül*; Ш *kil*;

¹³⁸ Ш *quntı*;

¹³⁹ К *qorʰy*;

¹⁴⁰ М (*e*)*ls(e)r*; К *ʰlsʰr*; Х *el esir*; Ш *al asir*;

¹⁴¹¹⁴¹ Ш *quntı*;

¹⁴² К *jaratdy*; Х *jaratdı*; Ш *bıjrutdı*;

¹⁴³ К *uıyʰrʰm*; Х *uıyurım*; Ш *uıyurım*;

¹⁴⁴ К *taj*; Х ⁴⁷⁴⁻⁴⁷⁵*altı aj*; Ш ⁴⁷⁴⁻⁴⁷⁵*altı aj*;

Тэсийн гэрэлт хөшөө:

W4 uууг qanīm tutulmīš.... (Уйгур хаан минь баригджээ.)

(Болд, 2006, s. 224) Уйгарын хан минь (төрийг) барилцаж байсан.

W5 ... qanīm yaši tāgip ucdī (хаан минь нас нь болоод халив.)

(Osawa, 1999, pp. 159, 160) Qan suffered great damages and he flew away (i.e. he died).

N1 tāgri qilintuq[da] (Тэнгэр үүсэхэд.)

(Osawa, 1999, p. 160) I heard that before Tāgri was created...

(Болд, 2006, s. 224)...Тэнгэр өршөөн соёрхсон (тул)д ...

N1 bök uluу qayan... (Бөк Их хаан)

(Osawa, 1999, p. 160) I heard that (they were) exalted and great Qayans.

(Болд, 2006, s. 224) (Тэр хаан маань) баатарлаг их (цэцэн) хаан (байсан)...

(Osman, 2009, p. 129) (O) yüce ve ulu kağan [imiş]

(Erhan, 2011, p. 33) (O) yüce (v) büyük kağan [imiş]

N3 uçuz kölkä atlırın tökä barmis (Учуз нуурнаа морьтонтой нь дайран оджээ.)

(Erhan, 2011, s. 34) Uçuz Gölü'ne atlarıyla (birlikte) döküvermiş.

N5 lön[rä]¹⁴⁵ tabyaçqa (lөмнө дийн Нангиад-д)

(Болд, 2006, p. 225) ... өмнө нь табгачид...

(Кляшторный, 2010, p. 88)... В прежние времена.

E2 anta adin¹⁴⁶ ödkünč¹⁴⁷ qayan ägmis¹⁴⁸ (Тэнд өөрхүүрамч хаан байжээ.)

(Шинэхүү, 1980, p. 41) Үүнээс гадна Өдкүнч хаган байсан бөлгөө.

(Харжаубай, 1979, p. 122) Бас Өткүнч хаган байсан бөлгөө.

(Болд, 2006, p. 225) Түүнээс гадна Өтүнч хаан (гэж) байсан.

E3 ančiryaši tägdī (тийн нас нь болов.)

(Osawa, 1999, p. 161) Then he suffered great damages.

E4 ... il tut[dī]

(Osman, 2009, p. 133) Halkı yönetti.

E6 bulaqıyüya¹⁴⁹ bašip¹⁵⁰ olurti .. (Булак-ыг эзэгнэн дарангуйлан суув...)

¹⁴⁵ M...re; K [...öŋ]re; III ...rä;

¹⁴⁶ K -d'n; X edin;

¹⁴⁷ K öd kenč; X ötkünči;

¹⁴⁸ M (e)rm(i)š; K e'rm'š; X ermis;

(Шинэхүү, 1980, р. 41) Йоллуг эзэн ахлан суув.

(Харжаубай, 1979, р. 122) Йоллуга эзэн ахлан байв.

S2 [t]äzig qašar¹⁵¹ qurıy¹⁵² qontı (Касар(ын) баруунтаа Тээ-д нутаглав.)

(Шинэхүү, 1980, р. 41) ... хашига (хашиг) хоригий нь эвдлэв.

(Харжаубай, 1979, р. 122) ... хашиг хориг босгож

S3 bälgüsin¹⁵³ bitigin bu urtı bu yaratdı (Тэмдгээ, бичгээ энэ цохив. Энэ бүтээв.)

(Шинэхүү, 1980, р. 41) Билигүүн үйлс бичиг юүгтээн энд сийлэхийг соёрхов.

(Харжаубай, 1979, р. 122) Билэгт үйлс бичиг юүгтээн энд сийлж, энд босгов.

Хам сэдэвт хэтэрхий дулдуйдсанаас үүдсэн орчуулгын(утгын) зөрүү

Тэсийн гэрэлт хөшөө:

N4 [bäldi]¹⁵⁴ bärsil¹⁵⁵ gadır qašar¹⁵⁶ anta barmıs (Бэди Бэрсил, Кадыр, Касар тэнд оджээ.)

(Шинэхүү, 1980, р. 41) хатүү хашиг тэнд очлоо.

(Харжаубай, 1979, р. 122) нэг эл үлсхажир /ширүүн/ эсэргүүцэж тэнд очив.

N5 [ön]rā¹⁵⁷ tabıačqa bazlanmıš¹⁵⁸ uyur qayanı toq olurmıs yetmis yıl ärmıs (Өмнө)дийн Нангиад-д эрхшээгдсэн. Уйгур хаан цатгалан суужээ. Далан жил байжээ(=оршжээ.)

(Шинэхүү, 1980, р. 41) ...өмнө зүгийн табгачи (нанхиадад)-д уйгур хаган эс орсны түл сэтгэл хангалуун 70 жил суулаа.

(Харжаубай, 1979, р. 122) Нанхиадад эс автагдсан Уйгур хаган цатгалан (сэтгэл хангалуун) суув. Далан жил суув.

(Osawa, 1999, p. 161) I heard that formerly they (i.e.Uyur Qayans) were reconciled to China.

(Erhan, 2011, s. 34) doğuda Çin'e tâbi olmuş.

E2 qayan ärmıs qayaneki¹⁵⁹ ärmıs¹⁶⁰ (Хаан байжээ. Хаан хоёр байжээ.)

¹⁴⁹ K *aja*;

¹⁵⁰ K *b^ašy*; X⁴⁵³⁻⁴⁵⁴ *ıyastı*; III⁴⁵³⁻⁴⁵⁴ *ıjasi*;

¹⁵¹ X *qašır*;

¹⁵² K *qorıy*; X *doruy*; III *qorıy*;

¹⁵³ M *b(e)lgüsin*; K *b^elgüš'n*; X *bilgü isin*; III *biligüsin bitigüsin*;

¹⁵⁴ M [*(e)b*]di; K [*...b^e*]di; III;

¹⁵⁵ M *b(e)rs(i)l*; K *b^ers'l*; X *bir el*; III *ab är il*;

¹⁵⁶ X *qašır*; III *qašır*;

¹⁵⁷ M *...re*; K [*...ön]re*; III *...rā*;

¹⁵⁸ K *qyz^a s'nm^aš*; X *bazlanmaš*;

¹⁵⁹ III *aki*;

(Харжаубай, 1979, р. 122) байв. Хаган хоёр сар байв.

E5 ... öngrä¹⁶¹ kün tüşigdaqi bodun... (...өмнөш наран мандах (зүг) дэх ард түмэн ...)

(Шинэхүү, 1980, р. 41) ... наран мандах зүүн зүгийн хүн ард

(Харжаубай, 1979, р. 122) ... наран ургах дорно зүгийн ард түмэн

(Osman, 2009, s. 161) doğudaki / gün doğusundaki halkları ...

(Erhan, 2011, s. 36) ...doğuda güneşin doğduğu yerdeki halklar...

Нийтдээ давхардсан тоогоор орчуулгын зөрүү тавь гаруй ажиглагдсанаас хоёрдугаар зүйл буюу үсэг тэмдэгтийг ижил сэргээсэн боловч амилуулан уншихтай холбогдсон орчуулгын зөрүү зонхилж, дөрөвдүгээр зүйл буюу хам сэдэвт хэт дулдуйдсанаас үүдсэн зөрүү маш бага ажээ. Үүнээс үзэхэд, эрдэмтдийн орчуулга хэдийгээр тайлбар орчуулга боловч эрдэм шинжилгээний орчуулга гэдэг утгаараа хам сэдэвт төдийлөн баригдсангүй, харин бичээст тохиолдох оноосон нэрийг орчуулан буулгах, эс бөгөөс галиглан хэвээр үлдээхтэй холбогдсон зөрүү түлхүү ажиглагдаж байна.

Эцэст тэмдэглэхэд, хөшөөний бичээсийг нүдээр үзэж, эх бичгийн судалгаа хийгээгүй, гэрэл зураг болон өмнөх эрдэмтдийн судалгаа тэргүүтэнд тулгуурласан бүтээл нь хэр үнэн, үнэ цэнэтэй нь зарим талаар эргэлзээ төрүүлдэг ч манай түүхчид Уйгурын түүхийн судалгаандаа гадаадын эрдэмтдийн судалгааг түлхүү ашиглаж баримталсаар ирсэн байна.

Энэ нь манай эрдэмтдийн уг түүхэн сурвалжийн орчуулга судалгаа багагүй зөрүүтэй байдагтай шууд холбоотой хэмээн үзэж болно. Өөрөөр хэлбэл, дан ганц гэрэлт хөшөөний орчуулгын жишээнээс л үзэхэд дээрх мэт байгаа нь Уйгурын үеийн сонгодог руни бичгийн дурсгалын эх бичгийн судалгааг дахин нягтлан судлах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

¹⁶⁰ M (e)rm(i)s; K ^erm's; X ermis;
¹⁶¹ K öngre;

Номзүй

1. Erhan, A. (2011). *Uygur Kağanlığı Yazıtları*. Konya.
2. Osawa, T. (1999). Tes Inscription. In *Provisional report of researches on historical sites and inscriptions in Mongolia from 1996 to 1998* (pp. 158-167). The Society of Central Eurasian Studies.
3. Osman, M. (2009). *Ötüken Uygur Dönemi Yazıtlarından, Tes, Tariat, Şine Us*. Ankara.
4. Болд, Л. (2006). *Орхон бичгийн дурсгал II*. Улаанбаатар.
5. Кляшторный, С. (2010). *Рунические памятники Уйгурского Каганата и история евразийских степей*. Санкт-Петербург.
6. Харжаубай, С. (1979). Тэсийн гэрэлт хөшөө. *Хэл зохиол судлал, Том. XIII, fasc.15*, 117-124.
7. Шинэхүү, М. (1980). Орхон-Сэлэнгийн руни бичгийн шинэ дурсгал. *Археологийн судлал, Том.VIII, fasc.1*.